

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
5 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

2021 оны 5 дугаар сарын 14-ны өдөр Нийгмийн хамгаалал байгаль орчны бодлогын асуудал эрхэлсэн хурлын хороогоор “Нэг өрх-Нэг ажлын байр” дэд хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлээ. Мөн “Жендерийн эрх тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөр, “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх” аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг сонсож, санал дүгнэлтээ хүргүүлээ.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газартай хамтран “Хүчирхийлэлгүй гэр бүлийн төлөө хамтдаа” аяныг 2021.05.03-20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгууллаа. Тус аяны хүрээнд “Хамтдаа хамгаалъя” сэдэвт цахим сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 19 сумын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга зүйн чиглэлээр мэдлэг олголоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Засгийн газар болон, аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тухайн онд дэвшүүлсэн зорилт, чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний үүргээ амжилттай хэрэгжүүлж ажилласан Хайрхан, Цэнхэр, Цахир, Хотонт, Эрдэнэбулган сумдын Засаг даргын Тамгын газрыг “Өргөмжлөл”-өөр, Хайрхан, Цэнхэр, Эрдэнэбулган, Хотонт сумдын Засаг дарга нарыг нэг сарын цалинтай тэнцэх мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

5-р сарын 07-ны өдөр аймгийн Онцгой комисс цахимаар хуралдаж, аймгийн хэмжээнд “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-ийг “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлж гамшгийн зэрэглэлийг нэг шатаар бууруулж 2021 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл хугацаанд “Улбар шар” түвшинд шилжүүлээ.

Аймгийн АВ, Тамир, Өнгө студи зэрэг телевиз, цахим сайтуудаар өдөр бүр 10:00 цагаас аймгийн Засаг дарга Д.Золжаргал, аймгийн Засаг даргын орлогч В.Мөнхбат, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Д.Эрдэнэбаатар, Эрүүл мэндийн газрын дарга Р.Гандиймаа нар коронавируст халдварын нөхцөл байдлын мэдээ, урьдчилан сэргийлэх ажил болон хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар иргэдэд хүргэж байна.

Архангай аймагт сүүлийн 24 цагт 383 шинжилгээ хийгдсэн. Шинээр илэрсэн тохиолдол 4 байна.

Үүнд: Өлзийт – 1, Өгийнуур – 2, Эрдэнэмандал – 1 тохиолдол байна.

Архангай аймагт нийт COVID-19-ын батлагдсан тохиолдлын тоо 372 боллоо. Үүнд:

2020 онд: Батцэнгэл – 3 тохиолдол

2021 онд: Эрдэнэбулган – 189 тохиолдол

Хайрхан – 31 тохиолдол

Эрдэнэмандал – 60 тохиолдол

Чулуут – 17 тохиолдол

Ихтамир – 1 тохиолдол

Цэнхэр – 14 тохиолдол

Хотонт – 5 тохиолдол

Тариат – 1 тохиолдол

Өлзийт – 38 тохиолдол

Жаргалант – 4 тохиолдол

Өгийнуур – 9 тохиолдол тус тус бүртгэгдээд байна.

Эмнэлэгт хэвтэж байгаа: 46

Эмнэлгээс гарсан: 326

Ойрын хавьтлын хүний тоо: 3115 /нийт өссөн дүнгээр/

Одоо тусгаарлах байранд байгаа – 13

Одоо гэрийн тусгаарлалтад байгаа – 746

Аймгийн хэмжээнд 23 цэгээр коронавируст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулалтыг зохион байгуулж, 2021 оны 05-р сарын 30-ны өдрийн 00.00 цагийн байдлаар I тунд – 49196, II тунд – 27506 хүнийг дархлаажуулаад байна.

Сүүлийн 24 цагт голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийгээгүй байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлт

2021 оны 5 дугаар сард орлогын төлөвлөгөөг хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 147.1 сая төгрөг, аймгийн төсөвт 873.2 сая төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Цахимаар татвар төлөх талаар видео бичлэг, татварын тайлан хүргүүлэх хугацааг сануулсан, татвар хууль тогтоомжтой холбоотой 36 мэдээ, мэдээллийг Архангай аймгийн татварын хэлтсийн пэйж хуудсанд 2-3 удаагийн давтамжтайгаар байршуулан, 2533 хүн үзэж, 974 хүн шейр хийж, бусдад түгээсэн.

Татварын хууль тогтоомж, татварын тайлан гаргах, цахимаар татвар төлөлтийн талаар 326 татвар төлөгчид утсаар зөвлөгөө өгч, ибаримтын нэвтрэх нэр, нууц үг авах хүсэлт гаргасан 90 татвар төлөгчид нэвтрэх нэр нууц үгийг олголоо.

Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамрагдсан 1288 татвар төлөгчийн 547.9 сая төгрөгийн буцаан олголтыг татвар төлөгчдийн дансанд арилжааны дамжуулан шилжүүллээ.

Хөрөнгө оруулалт

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 41.177.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.666.2 мянган төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ, авто замын сангийн хөрөнгөөр 315.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр тус тус батлагдсан байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа

Орон нутгийн өмчит 17 төсөвт байгууллагад 63.1 сая төг-ийн үндсэн хөрөнгө худалдан авах, 3 төсөвт байгууллагад 47,9 сая төг-ийн өртөг бүхий үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрлийг тус тус олгосон байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор хувьчлахаар шийдвэрлэсэн үл хөдлөх хөрөнгийн нийтийн дуудлага худалдааг 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, 12 ширхэг үл хөдлөх хөрөнгө, 3 ширхэг автомашин худалдахаас 5 барилгыг дуудлага худалдаагаар худалдаж, орон нутгийн төсөвт 22.6 сая төгрөг төвлөрүүлэх болов.

2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 5 тэрбум 123.7 сая төгрөгийн 26 төсөл арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай 16 төсөл арга хэмжээ эрх шилжиж ирсэн. Гэрээ байгуулах эрх олгосон 573.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл арга хэмжээ, тендер нээж, үнэлгээ хийгдэж байгаа 3 тэрбум 373.0 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ, тендер зарласан 1 тэрбум 60.0 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ, шууд худалдан авалт хийхээр төлөвлөж байгаа 14.7 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ, Сангийн яамнаас хүчингүй болгох шийдвэр гарсан 23.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ, амжилтгүй болж дахин хуулийн дагуу тендер зарлахаар төлөвлөж байгаа 80.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ байна. Холбогдох захиалагч байгууллагаас ТЭЗҮ болон ажлын даалгавар ирүүлсэн тухай бүрт үнэлгээний хороо байгуулан хууль дүрэмд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Зохион байгуулж байгаа нийт худалдан авалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Санхүүгийн хяналт

“Архангайд үйлдвэрлэв” орон нутгийн өмч аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Цөм сүргийн үржлийн төв, Аялал жуулчлалын мэдээлэл, үйлдвэрлэлийн төвүүдэд аудит, хяналт шалгалт хийгдэж, тайлагнах шатандаа явж байна. Монгол улсын Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн хүрээнд газрын нөхөн төлбөрийн ногдуулалт, төлөлтийн байдалд болон иргэний өргөдөл хүсэлтээр Эрдэнэбулган сумын ЗДТГ-т хяналт шалгалт хийгдэж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд Хууль, хяналт

2021 оны 5 дугаар сард гамшиг, аюулт үзэгдэл, ослын 8 дуудлага хүлээн авснаас объектын галын дуудлага 4, хүчтэй салхи шуурга 2, хүний гоц халдварт өвчин 1, газар хөдлөлт 1-ийг тус тус хүлээн авч ажлыг шуурхай шийдвэрлүүлсэн байна.

Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу Архангай аймгийн нутаг дэвсгэрт байршилтай уул уурхай, баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 5 дугаар сарын 03-ны өдрөөс 20-ны өдрийн дотор зохион байгууллаа.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Хүүхэд хамгааллын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 20-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Шалгалтанд 3 байгууллагын 5 объект хамрагдаж, Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм, журам, заавар болон галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 14 зөрчил илрүүлж, 6 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан бусад зөрчлүүдийг арилгуулахаар гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 3-ийг бичиж байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлээ.

/Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мөрдүүлэх, хүн хоорондын зай бариулах, амны хаалт тогтмол зүүлгэх, ариутгал, халдваргүйжүүлэлт, агаар сэлгэлт тогтмол хийлгэх, халуун хэмжих, QR код уншуулж бүртгүүлэх талаар Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа Хүнсний дэлгүүрүүд, худалдааны төвүүд болон төрийн байгууллагуудын нийт 1800 гаруй ажилтан, албан хаагч, иргэдэд заавар, зөвлөмжийг өгч, аж ахуйн нэгжийн ариутгал, халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавьж, иргэд олон нийтийг амны хаалт /маск/ зүүхийг уриалж ажиллаж байна.

Шинэ Коронавируст Covid-19 цар халдвараас урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээ мэдээлэл, заавар зөвлөмж, цаг үеийн мэдээг өдөрт 2-4 удаагийн давтамжтайгаар олон нийтэд мэдээлж Онцгой байдлын газрын пэйж хуудсанд дээрх мэдээг байрлуулж 29.417 иргэнд хүрч хандалт авсан байна.

Гал унтраах автомашины чанга яригч, аймгийн төвийн узель, Цагдаагийн газрын чанга яригч бүхий автомашинаар Эрдэнэбулган сумын ард иргэдэд урьдчилан сэргийлэх сурталчилгааг өдөр бүр хүргэж ажиллаж байна. 4 дүгээр сарын 29-ний өдрөөс 5 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл аймгийн хэмжээнд хатуу хөл хорио тогтоон халдваргүйжүүлэлт хийж байгаатай холбогдуулан Онцгой байдлын газрын гал унтраах автомашины чанга яригчаар иргэдийг гэрээсээ гарахгүй байх талаар сэрэмжлүүлэг хүргэн 500 ширхэг санамж тараасан байна.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, шар усны үерээс урьдчилан сэргийлэх, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээ мэдээлэл төрлийн шторкыг “АВ”, “Тамир” телевизүүдээр өдөрт 10 удаагийн давтамжтайгаар нийт

220 минут нэвтрүүлж урьдчилан сэргийлэх чиглэлээр 29.000 иргэнд ухуулга сурталчилгаа хийж ажиллалаа.

2021 оны 4-р сард аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 130 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 44, хулгайлах гэмт хэрэг 37, малын хулгайн гэмт хэрэг 22, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 10, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 36, гэмт хэргийн илрүүлэлт 27.0 хувьтай байна.

Нийт 4949 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 4656 иргэнд 195929.1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 286.5 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 55 0 хувьтай байна.

Шүүхийн шинжилгээний алба 5-р сард криминалистикийн шинжилгээ 8, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 48, шүүх эмнэлгийн шинжилгээ 30, тусгай шинжилгээ 8-г хийсэн байна.

Мэргэжлийн хяналтын газар улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын баталсан журмын дагуу 12 дугаар ангийн давтлага зохион байгуулж буй 20 ЕБС-ийн ахлах сургуулиудад постер, улсын байцаагчийн зөвлөмжийг өгч ажиллаж байгаа бөгөөд 171 дүгээр тушаалын хэрэгжилт 81.6 хувьтай хэрэгжиж байна.

Дархлаажуулалтын цэгүүдэд байнгын шалгалт хийж, вакцины хэм, зай барих, гар халдваргүйжүүлэх, халуун үзэх, эмчийн үзлэг, вакцины технологи үйл ажиллагаа, хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлт, устгалын байдалд хяналт хийж байна.

Засгийн газар, улсын Онцгой комисс, аймгийн Онцгой комиссоос хязгаарлалт тогтоогоогүй үйлдвэрлэл, үйлчилгээний төрийн байгууллагуудад улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар батлагдсан тусгай нөхцөл шаардлагыг хангуулах ажлын хүрээнд 121 аж ахуй нэгж, байгууллага, иргэний үйл ажиллагаанд 4 хяналтын чиглэлээр, 3 төрлийн 89 ширхэг зөвлөмж, мэдэгдлийг хүргүүлснээс биелэлт 76 хувьтай байна.

Худалдаа, үйлчилгээ, үсчний салон, халуун усны газар, бүх шатны боловсролын байгууллагын халдваргүйтгэлийг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, үйлчилгээний талбайд зай барих тэмдэг тэмдэглэгээг байрлуулж, гар ариутгах нөхцлийг бүрдүүлж, халдвар хамгааллын дэглэмийн байдалд байнгын хяналтыг хийж байна.

Коронавирусын халдвар гарсан Өлзийт, Цахир, Хотонт, Хайрхан суманд аймгийн Шуурхай штабаас томилсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 4 улсын байцаагч ажиллаж холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгаарлан ажиглах байр, Эрүүл мэндийн төв, түргэвчилсэн оношилгооны цэгүүд, голомтын эцсийн халдваргүйжүүлэлт, эргүүл постын үйл ажиллагаа, эмийн сан хүнсний дэлгүүрийн хүргэлтийн үйлчилгээ, халдвар хамгааллын дэглэмийг хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд нийт 633 объектын 107803 м.кв талбайд голомтын эцсийн халдваргүйжүүлэлт, нийтийн эзэмшлийн аспальтан зам, явган болон дугуйн зам, зогсоол, тоглоомын талбай, орон сууцны орц, хонгил зэрэг 355 объектын 349772 метр квадрат талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хяналт тавьлаа. Зооноз өвчин судлалын төв, тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, ариутгагчийн хувийн хамгаалах хэрэгсэл бүрэн өмссөн эсэх, халдваргүйжүүлэлт хийж буй бодис нь улсын бүртгэлд бүртгэгдэж зөвшөөрөгдсөн эсэх, бодисын хүрэлцээ хангамж, зааврын дагуу ашигласан байдалд хяналт тавин ажиллахад халдваргүйжүүлэлтийг улсын бүртгэлд бүртгэгдсэн бодисоор хийж, хамгаалах хувцас хэрэгсэлээр ариутгагч, албан хаагч нарыг бүрэн хангаж ажилласан байсан.

Засаг даргын архи согтууруулах ундаагаар үйлчилэхгүй хязгаарлалт тогтоосон захирамжийн хүрээнд Цагдаагийн газар Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, нийт 83853 ширхэг пиво, 13954 ширхэг вино, 210526 ширхэг архи согтууруулах ундааг тоолж битүүмжиллээ.

Хаяг шошгын зөрчилтэй 5 нэр төрлийн 88 ширхэг 218000 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнд буцаан таталт хийлгэж, хадгалалтын хугацаа дууссан 9 нэр төрлийн 65 ширхэг, 175800 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг байгууллагын дотоод хяналтаар устгууллаа.

2021 оны 5 сарын байдлаар 73 сорьцонд 283 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийж гүйцэтгэлээ. Үүнээс 40 үзүүлэлт нь стандартын шаардлага хангаагүй байгаа нь нийт сорьцын 14.1% эзэлж байна.

Стандарт, хэмжил зүйн 1 аж ахуй нэгж, 21 иргэний тохирлын гэрчилгээ сунгуулах, болон шинээр авах хүсэлтийн дагуу тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, аж ахуй нэгж, иргэдэд тохирлын гэрчилгээ олгож эзэлхүүн хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын чиглэлээр 13 сумын 35 ШТС-ын 72 ширхэг түгээгүүрт /128 ширхэг хошуу/ хаврын ээлжит баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хаврын ээлжит баталгаажуулалтын ажлаар сумдын худалдаа үйлчилгээ эрхлэгч, аж ахуй нэгж, байгууллагуудын массын хэмжих хэрэгсэлд ээлжит баталгаажуулалтын ажлыг ном журмын дагуу хийж гүйцэтгэлээ. Баталгаажуулалтад Өндөр-Улаан сум-26 ширхэг хэмжих хэрэгсэл, Тариат сум-27 ширхэг хэмжих хэрэгсэл, Хангай сум-20 ширхэг хэмжих хэрэгсэл, Цахир сум-8 ширхэг хэмжих хэрэгслийг тус тус лацдаж баталгаажуулан, нийт 82 ширхэг массын хэмжих хэрэгсэл баталжуулалтад хамрагдлаа.

Мөн савласан бүтээгдэхүүний тоо хэмжээнд давхар хяналт шалгалтын ажлыг хийсэн. Нийт 82 ширхэг массын хэмжих хэрэгсэл баталжуулалтад хамрагдлаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсрол

Элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл өндөрлөв. ЭЕШ-ын бүртгэлийн хугацаа 1 удаа сунгагдан, 5 сарын 5-ны өдөр улс орон даяар зэрэг хаагдав. Архангай аймагт нийт 1119 шалгуулагч ЭЕШ-ын өгөхөөр бүртгүүлсэн байна. Эдгээр шалгуулагч нар 3068 шалгалт өгнө. ЭЕШ 7 сарын 1-4-ний өдрүүдэд Эрдэнэбулган сумын Лаборатори 1-р сургууль дээр явагдана.

2020-2021 оны хичээлийн жил өндөрлөж буйтай холбогдуулан хичээлийн жилийн дэвшилт, төгсөлтийн үйл ажиллагаа явагдаж байна. Ерөнхий боловсролын сургуулийг суурь, бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөж буй төгсөгчдөд боловсролын баримт бичиг олгох үйл ажиллагаа явагдаж байна. 5 сарын 28-ны өдрийн дотор 9, 12-р анги төгсөгчдөд гэрчилгээг бүрэн олгож дуусна. Архангай аймагт суурь боловсролыг 1404 сурагч, бүрэн дунд боловсролыг 1099 сурагч төгсөн гэрчилгээ авч байна.

Эрүүл мэнд

Ковид-19 цар тахалын үед эмнэлгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх үүднээс хандив тусламжаар 2,040,00 төгрөгийн өртөг бүхий 24 ширхэг пульсоксиметрийн эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгч, аймгийн Нэгдсэн эмнэлэгт Глобаль сангийн дэмжлэгтэйгээр зөөврийн дижитал рентген аппаратын хангалтыг хийсэн.

КОВИД-19 цар тахлын үед үр бүтээлтэй ажилласан 21 эмнэлгийн ажилтан төрийн одон медалиар 3 хүн ЭМЯ-ны шагналаар, 30 гаруй хүнийг аймгийн шагналаар тус тус шагнасан.

Нэгдсэн эмнэлгийн молекул биологийн лабораторит бх-ПГУ-ын 8709 шинжилгээ хийснээс 81 эерэг тохиолдол батлагдсан бөгөөд батлагдсан тохиолдлуудыг Нэгдсэн эмнэлгийн болон сумын эрүүл мэндийн төвүүдийн тусгаарлан эмчлэх эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн.

Эрдэнэбулган, Хотонт, Цэнхэр, Эрдэнэмандал, Өлзийт, Хайрхан суманд батлагдсан коронавирүст халдварын 81 тохиолдлын хавьтлуудыг тандан судалж, 885 ойрын хавьтлыг тогтоож, тусгаарлалтанд авч хянасан.

2361 хүнийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулж, 12 тохиолдол эерэг илэрсэн.

Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 5 удаагийн татан авалтаар нийт 94400 хүн тун коронавирүсийн эсрэг вакциныг татан авч, вакцинжуулалтын цэгүүдэд хуваарилсан.

Вакцинжуулалтын 23 цэгт нийт 44897 хүнийг коронавирүсийн эсрэг вакцины 1 дүгээр тунд, 12291 хүнийг 2 дугаар тунд хамруулсан.

5 дугаар сарын 06-ны өдөр 2021 оны 2-р улиралд эндсэн 0-5 настай хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх хурлыг цахимаар зохион байгуулж, материалыг ЭХЭМҮТ-ийн тандалт судалганы алба болон ЭМЯаманд илгээсэн.

5 дугаар сарын 06-ны өдөр ШУГТЭ-ээс олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан нийт сувилагч, тусгай мэргэжилтний дунд зохион байгуулж буй “Коронавирус (Covid-19)-үеийн мэс засал, мэдээгүйжүүлгийн сувилахуйн тусламж үйлчилгээ” сэдэвт үндэсний VII цахим сургалт, семинарт ЭМБ-ын 15 сувилагч тусгай мэргэжилтнүүд хамрагдав.

Соёл урлаг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигаар жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоногийн ням гаригт Үндэсний бичиг үсгийн баярыг улс орон даяар зохион байгуулдаг уламжлалын дагуу “Үндэсний бичиг үсгийн баяр-2021” арга хэмжээг 5 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд “Зөв сайхан бичигтэн”, “Түргэн уншлага”, “Уран бичлэг”-ийн уралдааныг 3 насны ангиллаар зохион байгуулж, уралдааны төрөлд давхардсан тоогоор 186 оролцогч хамрагдлаа. Энэ жилийн арга хэмжээ нь аймгийн Засаг даргын ивээл дор, анх удаа цахимаар зохион байгуулснаараа онцлог байв. Уралдааны ангилал тус бүрд 3 байр шалгаруулж, өргөмжлөл мөнгөн шагналаар урамшууллаа.

2021 оны 5 дугаар сарын 20 -ны өдөр Соёлын яам, нийслэлийн тэргүүний 1 дүгээр сургуультай хамтран орон нутгийн музейн цахим аялалыг зохион байгууллаа. Цар тахлын үед хичээл сургалтын үйл ажиллагаа цахим болсонтой холбогдуулан сурагчдын хөгжих боломжийг нээж “Цахим аялалд” орон нутгийн 10 музей хамтран оролцож Нийслэлийн тэргүүний 1 дүгээр сургуулийн 6-8-р ангийн 500 гаруй сурагчид цахимаар музейтэй танилцлаа. Сурагчдад үр өгөөжтэй сонирхолтой арга хэмжээ боллоо.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2020 оны 5 сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1365 иргэн бүртгэлтэй байгаагаас 672 эмэгтэй. Шинэ ажлын байр 208 үүнээс байнгын ажлын байр 114, улирлын ажлын байр 31, түр ажлын байр 63 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 246, зуучлал 234 байна. Тухайн сарын 20-ны байдлаар 83 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 9, бага- 68, суурь-228, бүрэн дунд- 814, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 29, тусгай мэргэжлийн дунд-26, Дипломын бакалаврын-191 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 8 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч ЭМНДХэлтэс рүү хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын санд 2021 оны 5 дугаар сарын 25-ны байдлаар нийт 7393.6 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 109 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 15.8 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 22.7 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 1787.3 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Гэр бүл, хүүхэд, залуучууд

Гэр бүлийн боловсрол, мэдээлэл олгох, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 64 зурагт хуудас, 3 дүрст мэдээлэл, “Хүчирхийлэлгүй гэр бүлийн төлөө” аяны хүрээнд 48 зурагт хуудсыг, хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр өсвөр насны

сурагчдын цахим ярилцлага, 60 зурагт хуудас, 1 дүрст мэдээллийг тус тус бэлтгэн цахим хуудсаар дамжуулан түгээж, 48.000 орчим хүнд хүргэсэн байна.

“Хүүхдийн элчийг чадавхижуулах” цахим сургалтыг 15 сумын 15 хүүхдийн элчийн оролцоотой, сумын хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах цахим сургалтыг 18 сумын 72 гишүүнийг хамруулан тус тус зохион байгуулж, тэднийг мэргэжил, арга зүйгээр хангаж, зөвлөгөө мэдээлэл өглөө.

Хүүхдийн эрхийг хамгаалах аяныг зохион байгуулж, 9 сумын ЕБ-ийн 6 сургууль, 9 хүүхдийн цэцэрлэг нийт 15 байгууллага идэвхитэй оролцсон бөгөөд 540 гэр бүл, 1619 хүүхдийг хамруулж, байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлж, гэр бүлийн орчинд хүүхдийн эрх хангагдах нөхцлийг бүрдүүлэх, гэр бүлдээ, хүүхдэд чанартай цаг гаргахад нөлөөлж, гэр бүлд хүүхдийг сонсож, тэдний оролцоотой асуудлыг шийдвэрлэхэд нь мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд шилжиж ирсэн 5 дуудлага мэдээллийг хүлээн авч холбогдох сум, байгууллагад шилжүүлж, 9 дуудлага мэдээллийг шийдвэрлээд байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны зүгээс 2 хүүхдийн асуудалд хууль эрх зүйн болон холбон зуучлах үйлчилгээ үзүүлсэн. 4 хүүхдийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийж, холбогдох байгууллагад уламжлаад байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А-45, А-72 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны А/158, А/239 дүгээр захирамжийн дагуу баталгаажсан үүлдэр омгийн малд үзлэг ангилалт хийж баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, мөн “Малын бүртгэлжүүлэлтийн аян”-ы хүрээнд малыг засаг захиргаа нутаг дэвсгэрийн статистик бар-код бүхий үл давтагдах хувийн дугаартай ээмгээр ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулах ажлыг технологийн хугацаанд зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны 5 дугаар сарын 24-ний байдлаар 449 малчинд 5.9 тэрбум төгрөгийн малчдыг дэмжих зээлийг олгоод байна.

2020 оны эцэст манай аймгийн хэмжээнд 1489.2 мянган толгой ямаа тоолуулсан бөгөөд 491 тн ноолуур бэлтгэгдэж 60 тэрбум төгрөгийн орлого ноолуур бэлтгэн нийлүүлсэн иргэдийн гар дээр очно. Мөн 2020 онд үндэсний үйлдвэрт тушаасан давхардсан тоогоор 16.0 мянган малчин, мал бүхий иргэдийн ноос, арьс, ширний урамшуулалд нийтдээ 5.0 тэрбум төгрөг малчдын дансанд 5 дугаар сарын 12-ны өдөр орсон. Сумдад ноолуур бэлтгэлийн ажил үндсэндээ 128.0-130.0 мянган төгрөгийн ханштайгаар дуусч байна.

Энэ онд бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготнотой хавар 15.0 мянган га бэлчээрт микро биологийн аргаар, намар 40.0 мянган га бэлчээрт энгийн механик биологийн аргаар нийт 55.0 мянган га бэлчээрт тэмцэх ажлыг зохион байгуулах бөгөөд Хашаат, Өгийнуур, Батцэнгэл, Хангай сумуудад 15.0 мянган га талбайд микробиологийн аргаар тэмцэх ажлыг эхлүүлээд байна.

Архангай аймгийн хэмжээд 2020 онд үндэсний үйлдвэрт хонь тэмээний ноосоо нийлүүлсэн 9520 малчин, мал бүхий этгээдийн 2365,6 тн ноосонд 3,5 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллын баримт бүртгэгдсэн бөгөөд үүнээс 8943 малчинд 3.1 тэрбум төгрөгийн урамшууллыг олгоод байна. Малчны хувийн данс хаагдсан, дансны мэдээлэл зөрүүтэй шалтгаанаар 375 малчинд урамшуулал олгогдоогүй хүлээгдэж байна.

Аймгийн хэмжээнд энэ онд төллөвөл зохих 1983.6 мянган толгой хээлтэгч малын 83.0 хувь буюу 1640.2 мянган толгой хээлтэгч мал төллөж 1546.5 мянган толгой төл мал 94 хувьтай бойжиж байна. Үүнээс: ингэ 179 буюу 52.0 %, гүү 37151 буюу 37.6 %, үнээ 90697 буюу 46.1%, эм хонь 1008739 буюу 89.8%, эм ямаа 503491 буюу 89.3 хувь нь төллөөд байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, “Сэг, зэм устгах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн А/117 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд том малын зүй бус хорогдлоор тэмээ 34, адуу 4083, үхэр 13978, хонь 36509, ямаа 28127 нийт 82731 толгой мал хорогдсоноос 49997 малын сэг зэмийг устгалын нүхэнд цуглуулан булах болон шатаах аргаар устгаж, нийтийн эзэмшлийн талбай-46487 м², хашаа хороо-37465 м², өтөг бууц-10460 м², худаг уст цэг-1472 м², бэлчээр-4580 м², агуулах зоорь, түүхий эд агуулах зоорь- 2130 м², устгалын цэг-7454 м², нийт 110048 м² талбайд халдваргүйтгэлийн ажил хийгдсэн. Ажлын явц 60.0 хувьтай байнга бөгөөд энэ ажлын хүрээнд 257 хүн, 50 машин техник дайчлан ажиллаж байна.

Газар тариалан

Аймгийн хэмжээнд 15.0 мянган га талбайд үр тариа, үүнээс Улаанбуудайн 10.0 мянган га талбайд, малын тэжээл 3300 га талбайд, хошуу буудай үрийн зориулалтаар 200 га талбайд, тосны ургамал 1500 га талбайд тариална. Төмс 264 га талбайд, хүнсний ногоо 139 га талбайд, жимс жимсгэнэ 69 га талбайд тариалахаар төлөвлөж байна.

Хаврын тариалалтын бэлтгэл ажилд зориулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Хөдөө аж ахуйг дэмжих санд 2220 тн үр, 133 тн шатахуун, 45 тн бордоо, 37758 литр ургамал хамгааллын бодис, 50 литр үр ариутгагчийн захиалгыг хүргүүлсэн. Үүнээс гадна Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны “Хөдөө аж ахуйг дэмжих” хөтөлбөр, “Нэг малчин-Нэг өвөлжөө-10 ар” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд малчин өрхөд тэжээлийн ургамал тариалахад дэмжлэг болгож энэ онд 700 гаруй га талбайд тэжээлийн ургамал тариалах үр, техник, шатахууны дэмжлэг үзүүлнэ.

Хаврын тариалалтын бэлтгэл ажил 50 гаруй хувьтай явагдаж байгаа бөгөөд тариаланчдыг Улаанбаатар хот, бусад аймгуудаас ирэхэд нь Коронавирусээс урьдчилан сэргийлэх вакцин, PCR-ийн шинжилгээнд хамруулж /356 тариаланч/ улс, аймгийн Онцгой комисс, сумын удирдлагуудтай хамтран халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн тариалалтын ажлаа саадгүй явуулах нөхцөл боломжоор хангаж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин

2021 оны Бүх нийтийн мод тарих үндэсний өдрийг “Иргэн бүр хашаандаа мод таръя” уриатайгаар зохион байгуулж аймгийн хэмжээнд хаврын мод тарилтаар 9 төрлийн 7990 ширхэг мод бут тарисан байна.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх “Цэцэрлэг бороо” экспедиц нь 2021 оны 3 дугаар сарын 31 /Булган сум/, 4 дүгээр сарын 22 /Ихтамир сум/, 23 /Булган сум/, 27 /Булган сум/, 5 дугаар сарын 8 /Өндөр-Улаансум, Доной баг/, 21 /Батцэнгэл сум/-ний өдрүүдэд түймрийн эрсдэл нэн их буюу ОНЦ АЮУЛТАЙ түвшинд байгаа сумдын нутагт тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, урвалж цацаж цаг агаарт зориудаар нөлөөлсөн. Үйл ажиллагаа явуулсны үр дүнд хуурайшлын зэргийг бууруулж, усан сан, гол горхийг тэтгэж, бэлчээрийн болон тарьмал ургамлын ургалтанд эерэгээр нөлөөлж, хөрсний чийгийн хэмжээ нэмэгдсэн. Байгалийн жамаар 0.3 мм хур тунадас орох тооцоотой байсныг зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулсны үр дүнд 2021 оны 5 дугаар сарын 22-ны өдөр зүүн болон зүүн өмнө талын сумдын нутгаар дундажаар 3.9 мм хур тунадасыг нэмэгдүүлэн оруулсан байна.

Барилга, дэд бүтэц

Архангай аймагт 2021 îä Óёс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 171 тэрбум 866.2 сая төгрөгийн өртөг бүхий 69 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг

хэрэгжүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна. 2021 оны 5-р сард дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

1. Булган сумын Соёлын төвийн барилгын ажил эхэлсэн. Гүйцэтгэл 50%
2. Булган сумын Соёлын төвийн барилгын ажил эхэлсэн. Гүйцэтгэл 45%
3. Жаргалант сумын Соёлын төвийн барилгын ажил эхэлсэн. Гүйцэтгэл 25%
4. Хашаат сумын Сургуулийн өргөтгөлийн барилгын ажил эхэлсэн. Гүйцэтгэл 40%
5. Чулуут сумын 320 суудалтай сургуулийн барилгын ажил-гүйцэтгэл-90%
6. Эрдэнэбулган сумын 3-р сургуулийн Урлагийн залны барилгын ажил гүйцэтгэл 90%
7. Өндөр-улаан сумын Хануй багийн бага сургуулийн барилгын ажил эхэлсэн. Гүйцэтгэл 60%
8. Цахир сумын Цэцэрлэгийн барилгын өргөтгөл-гүйцэтгэл-50%
9. Булган сумын Сургуулийн барилгын засвар тохижилтын ажилд Газрын гагнаас ХХК 198,9 сая төгрөгийн үнийн саналаар шалгарч, гэрээ байгуулан ажил эхэлж байна.
10. Аймгийн төвийн Цэнгэлдэх хүрээлэнгийн засвар шинэчлэлийн ажлын зургийн даалгавар боловсруулж БТСГ-т өгсөн.
11. Барилгын ажил эхэлсэн 6 барилгуудад үе шатны хяналт хийсэн.

Барилгын материалын лаборатори нь 8 иргэн аж ахуйн нэгж, байгууллагын цемент, элс, хайрга, тоосго, хүрмэн гулдмай, хүрмэн чулуу, бетон сорьц зэрэг 7 нэр төрлийн 26 дээжинд сорилт шинжилгээ хийж 22 дээжинд шинжилгээ хийн үр дүнг боловсруулан хүргүүлсэн бөгөөд 100010029401 тоот дансанд 476400 төгрөг төвлөрүүлж 566200 төгрөгний нэхэмжлэх өгсөн байна.

2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хяналт шинжилгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг засварлах талаар ГЗБГЗЗГ-ын 1/825 тоот албан бичиг, 2021 оны 04 дүгээр сарын 22-ны А/78 тоот тушаалыг тус газарт ирүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар хугацаатай үүрэг даалгавар өгсөний дагуу Хотонт, Өндөр-Улаан, Цэнхэр сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлж, ГЗБТ-ийн цахим системд арга хэмжэний нэр буруу орсон Өгийнuur, Төвшрүүлэх, Эрдэнэмандал, Тариат, сумдын 32 нэгж талбарын мэдээллийг засварлалаа

Хүнс, үйлдвэр, үйлчилгээ

Хүнсний нөөцийн сүүлийн 7 хоногийн судалгаагаар гурил 323.4 тн буюу 43 хоног, гоймон 36.9 тн буюу 3 хоног, будаа 65.6 тн буюу 17 хоног, сахар 50.2 тн буюу 20 хоног, ургамлын тос 17.1 тн буюу 10 хоног, давс 22.8 тн буюу 57 хоног, ундны ус 23.6 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 5.51 тн буюу 4 хоног, төмс 32.9 тн буюу 12 хоног, хүнсний ногоо 12.4 тн буюу 1 хоног, өндөг 1.09 тн буюу 18 хоногийн нөөцтэй байна.

Хаврын тариалалтад ажиллах техникийн бэлэн байдлыг хангаж 4 гинжит трактор, 342 дугуйт трактор, 26 анжис, 31 үр тарианы үрлэгч, 7 төмс, хүнсний ногооны үрлэгч, 11 бул, 39 борной, 10 өргөн холбоо, 7 сэндэчлүүр, 13 бүх төрлийн сийрүүлэгч, 3 бордоо, бууц цацагч, 8 хор цацагч, 3 бороожуулах станц, 3 төмс, хүнсний ногооны бага оврын иж бүрдэл ажиллаж байна.

Архангай аймгийн хэмжээнд 662 тн улаанбуудай, 17 тн арвай, 17 тн хошуу будаа, манжингийн 12 кг, луувангийн 20 кг, байцааны 1 кг, сонгины 30 кг, өргөст хэмхийн 0,5 кг, улаан лоолийн 1 кг, бусад 10 кг үрийн нөөцтэй байгаа мэдээтэй байна.

19 сумын хэмжээнд 441 тариаланч ковид-19 вакцины 1-р тунд, 41 тариаланч 2-р тунд хамрагдаад байна.

ХХААХҮЯам болон ХААДСангаас 50 кг шар лууван, 2,5 кг шар манжин, 10 кг хүрэн манжин, 50 кг сармис, 5 кг урт сонгинын хар үр, 0,5 кг тарвас, 0,5 кг бууцай, 3 уут өргөст хэмх, 0,1 кг улаан лооль, 2 кг чинжүү, 500 кг төл сонгинын үр нийт 2340591 төгрөгийн үрийг хөнгөлөлттэй үнээр авч 19 суманд хуваарилсан.

Ургамлын гарал үүсэл, пестицидийн бүртгэл, хяналтын систем нэвтрүүлэлтийн хөтөлбөрийн хүрээнд сумын тариалан эрхлэгч иргэд болон тариалангийн талбайн тоог

гаргаж өгсөн. 19 сумын хэмжээнд 446 тариаланчийн 490 талбай одоогоор бүртгэгдсэн судалгааг яамруу явуулав

2021 оны 04 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 70 шинэ ажлын байрыг бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар авч үзвэл Эрдэнэбулган 37, Булган, Батцэнгэл, Өгийнуур, Чулуут, Хотонт, Хангай сумдад 2-10 шинэ ажлын байрыг бий болсон байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны 05 дугаар сарын 24-ний байдлаар “Ажлын байрыг дэмжих” зээлийг 201 иргэнд 7.4 тэрбум төгрөг, 38 аж ахуйн нэгжид 7.0 тэрбум төгрөг, нийт 239 иргэн, аж ахуйн нэгжид 14.4 тэрбум төгрөгийн зээл олгож 660 ажлын байрыг хадгалсан байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oO-----